



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот

“Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх
Бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:


1. “Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000710



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДЭРГЭДЭХ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны дэргэд, тус Хорооноос хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, санхүүгийн зах зээлийн бодлогыг тодорхойлох, зохицуулах, хянахтай холбогдсон үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий Бодлогын зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-ийн бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Зөвлөл нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, бусад холбогдох хууль болон энэхүү журмыг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллана.

Хоёр. Бодлогын зөвлөл, түүний чиг үүрэг

2.1. Хороо дэргэдээ дараах чиглэлээр Бодлогын зөвлөлтэй байна:

- 2.1.1. Даатгалын;
- 2.1.2. Үнэт цаас /хөрөнгө/-ны зах зээлийн;
- 2.1.3. Бичил санхүүгийн;
- 2.1.4. ХАА-н бараа, түүхий эдийн зах зээлийн;
- 2.1.5. Уул уурхайн хөрөнгө оруулалт, эрдэс баялагын биржийн арилжааны орчны;
- 2.1.6. Санхүүгийн зах зээлийн эрсдэлийн удирдлагын;

2.2. Зөвлөл нь Хорооноос санхүүгийн зах зээлд баримтлах ойрын болон дунд хугацааны бодлогыг тодорхойлоход оролцох, хариуцсан санхүүгийн зах зээлийн салбарын чиглэлээр судалгаа хийх, энэ чиглэлээр иргэд, олон нийт, төрийн бус байгууллага, зохицуулалттай этгээдийн төлөөллөөс санал авах, хэлэлцүүлэг хийх, судалгаа, саналд үндэслэн дүгнэлт, зөвлөмж гарган Хороонд хүргүүлэх, санхүүгийн мэдлэгийг олон нийтэд хүргэх үндсэн чиг үүрэгтэй байна.

2.3. Зөвлөл нь энэхүү журмын 2.2-т заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлыг гүйцэтгэнэ:

2.3.1. санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого, зохицуулалтын талаар санал боловсруулах, дүгнэлт гаргах, холбогдох судалгаа хийх, зөвлөмж гаргах;

2.3.2. Хорооноос баримталж буй санхүүгийн зах зээлийн бодлоготой холбоотой зөвлөмж гаргах;

2.3.3. энэ журмын 2.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, хэрэгжилтийн явцад дүгнэлт өгөх;

2.3.4. Зөвлөл гаргасан шийдвэрийнхээ үндэслэл, ач холбогдлыг Хороо болон холбогдох нэгжид мэдээлэх;

2.3.5. санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа эрхлэж буй байгууллагын чадавхи, иргэдийн санхүүгийн боловсролыг хэрхэн сайжруулах талаар зөвлөмж гаргах, түүнийг хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;

2.3.6. санхүүгийн зах зээлийн бодлого, зохицуулалттай холбоотой бусад асуудал.

Гурав. Зөвлөлийн бүтэц

1.1. Зөвлөл нь дарга, 12 хүртэлх тооны гишүүнээс бүрдэх бөгөөд орон тооны бус гишүүнчлэлтэй байна.

1.2. Зөвлөлийн даргыг Хорооны гишүүдээс, гишүүдийг төрийн бус байгууллага, мэргэжлийн оролцогч, эрдэм шинжилгээний болон сургалт, судалгааны чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагад санал тавьж, шаардлага хангасан гэж үзвэл нэр дэвшигчдийг Хорооны хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлнэ.

3.3. Зөвлөлийн гишүүд нь дараах шаардлагыг хангасан байна:

3.3.1. өөрийн болон ажил байдлын тодорхойлолт;

3.3.2. эдийн засаг, банк, санхүү, даатгал, үнэт цаас, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн зах зээл, эрсдэлийн удирдлагын зэрэг санхүүгийн зах зээлийн мэдлэг, мэргэшлийн ур чадвартай байх;

3.3.3. мэргэжлийн ёс зүй, ажлын туршлагатай байх.

3.4. Зөвлөлийн даргын бүрэн эрхийн хугацаа Хорооны гишүүн байх хугацаанд, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа Зөвлөлийн даргын ажиллах хугацаанд хүчинтэй байх бөгөөд дарга, гишүүдийн хугацааг сунгаж болно.

3.5. Зөвлөлийн гишүүдийг дараах тохиолдолд гишүүнээс чөлөөлнө:

3.5.1. хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан;

3.5.2. үүрэгт ажилдаа хайнга хандсан, хангалтгүй биелүүлсэн талаарх тухайн Зөвлөлөөс дүгнэлт гарсан;

3.5.3. гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон;

3.5.4. ашиг сонирхлын зөрчил үүссэн;

3.6. Зөвлөлийн гишүүн хугацаанаасаа өмнө чөлөөлөгдсөн тохиолдолд өөр этгээдийг энэ журамд заасан шаардлага, горимын дагуу нөхөн томилно.

Дөрөв. Зөвлөлийн дарга, гишүүний эрх, үүрэг

4.1. Зөвлөлийн дарга дараах эрх, үүрэгтэй:

4.1.1. Зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хурлын тов тогтоох;

4.1.2. Зөвлөлийн хурлыг даргалах;

4.1.3. Зөвлөлийн чиг үүрэгтэй холбоотойгоор гишүүдэд даалгавар, чиглэл өгөх;

4.1.4. Зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох;

4.1.5. Хорооны хуралдаанд Зөвлөлийн шийдвэрийг, Зөвлөлийн гишүүдэд Хорооны шийдвэрийг тус тус танилцуулах, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих.

4.2. Зөвлөлийн гишүүн дараах эрх, үүрэгтэй:

4.2.1. Зөвлөлийн хуралд оролцож, өөрийн үзэл бодлыг илэрхийлэх;

4.2.2. хэлэлцэх асуудалтай холбогдуулж санал гаргах;

4.2.3. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх шийдвэрийн төсөл, баримт бичиг, холбогдох мэдээллийг гаргуулан авах, танилцах;

4.2.4. Зөвлөлийн даргын эзгүйд түүний томилсоноор, эсхүл тогтсон дарааллын дагуу хурал даргалах;

4.2.5. хуралдааны тэмдэглэлтэй танилцах;

4.2.6. ээлжит бус хуралдаан хуралдуулах санал гаргах;

4.2.7. Зөвлөлийн хуралдаанд өөрийн биеэр оролцож, хэлэлцэж байгаа асуудалд хариуцлагатай, нухацтай хандах;

4.2.8. Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг олон нийтэд тайлбарлахдаа зөвхөн албан ёсны шийдвэрийг танилцуулах;

4.2.9. ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх.

Тав. Зөвлөлийн хуралдаан

5.1. Зөвлөл нь улиралд нэг удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд даргын товлосноор эсхүл хуралдуулах санал гаргасан 2 ба түүнээс дээш Зөвлөлийн гишүүний хүсэлтээр ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

5.2. Хуралдааныг Зөвлөлийн даргын эзгүйд түүний томилсон гишүүн удирдан явуулна.

5.3. Хуралдаан нийт гишүүдийн ердийн олонхи оролцсоноор хүчин төгөлдөр болно.

5.4. Хуралдаанаар хэлэлцэж гаргасан шийдвэр нь санал хураалтаар шийдвэрлэгдсэн байна.

5.5. Хурлаас гаргах шийдвэр нь санал, зөвлөмж гэсэн хэлбэртэй байна:

5.5.1. Хурлаар тодорхой асуудлыг хэлэлцүүлэх, шийдвэрлүүлэхээр Хороонд хандаж санал гаргана;

5.5.2. Зөвлөл өөрийн санал санаачлагаар аливаа баримт, мэдээлэлд тулгуурлан хийсэн судалгааны үр дүнд үндэслэн Хороонд хандан зөвлөмж гаргана.

5.6. Зөвлөлийн дарга, гишүүдэд олгох урамшуулал, үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг Зөвлөлийн ажлын төлөвлөгөөг харгалзан тухай бүр Хороо шийдвэрлэнэ.

5.7. Зөвлөл өөрсдийн гишүүдийн гаргасан саналыг хэлэлцэн шийдвэрлэсний үндсэн дээр бусдаас санхүүгийн эх үүсвэр авч болно.

Зургаа. Зөвлөлийн нарийн бичгийн дарга

6.1. Зөвлөл нь нарийн бичгийн даргатай байна.

6.2. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Зөвлөлийн хуралдааны товыг зарлах, хэлэлцэх асуудлын жагсаалт гаргах, хуралдааны бэлтгэл ажлыг хангах, хуралдааныг зохион байгуулах болон Хорооны Ажлын албатай ажлын уялдааг хангаж ажиллах үүрэгтэй.

6.3. Зөвлөлийн нарийн бичгийн дарга хуралдаанаар хэлэлцэх асуудлын танилцуулга болон санхүүгийн зах зээлийн нөхцөл байдлын талаарх холбогдох мэдээлэл, тооцоолол, бодлогын шинжилгээг Зөвлөлийн гишүүдэд хурал эхлэхээс ажлын 3 хоногийн өмнө цахим хэлбэрээр хүргүүлнэ.

6.4. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хариуцан хөтлөх бөгөөд тэмдэглэлд хуралдаан даргалагч, тэмдэглэл хөтлөгч нар гарын үсэг зурснаар тэмдэглэл баталгаажна.

6.5. Хуралдааны тэмдэглэлд тухайн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын жагсаалт, хуралдаанд ашигласан мэдээ, баримт болон холбогдох материалыг хавсаргасан байна.

6.6. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлд хуралдаанд хэлэлцсэн асуудлаар гишүүдийн хэлсэн үг, гаргасан саналыг үнэн зөв, бүрэн гүйцэд бичиж, тэмдэглэнэ. Баталгаажсан тэмдэглэлд утга агуулгын өөрчлөлт оруулахыг хориглоно.

6.7. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Хорооны Ажлын албаны холбогдох нэгжийн албан хаагч байх бөгөөд хуралдааны тэмдэглэлийн нууцлалыг хангах, бүрэн бүтэн хадгалах үүрэг хүлээнэ.

**Долоо. Зөвлөлийн дарга, гишүүдийн үйл
ажиллагаанд хориглох зүйл**

7.1. Зөвлөлийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

7.1.1. аливаа улс төр, бизнесийн бүлэглэлийн шахалт дарамтад өртөж, тэдний хууль бус ашиг сонирхлыг илэрхийлэх;

7.1.2. нийтэд мэдээлээгүй мэдээ, мэдээллийг өөрийн болон бусдын эрх ашигт нийцүүлэн урвуулан ашиглах, бусдад задруулах, мэдээлэх;

7.1.3. санхүүгийн зах зээлд сөргөөр нөлөөлж болзошгүй мэдээ, мэдээллийг задруулах, олон нийтэд хүргэх;

7.1.4. Зөвлөлөөс гарах шийдвэр нь ямагт Хорооны бодлогод нөлөөлөхүйц байх тул нийтийн эрх ашгийг дорд үзэж, хувийн эрх ашгийн төлөөлж ажиллах.

Найм. Хариуцлага

8.1. Зөвлөлийн дарга, гишүүн нь тус журмын холбогдох заалтыг зөрчсөн нь тогтоогдвол гишүүнээс чөлөөлөхийн зэрэгцээ холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---